



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/36

Улаан-Уул

Байгаль хамгаалах арга хэмжээний
зардлаас хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө зарцуулах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрээр 1, 2, 3 дугаар саруудад авч хэрэгжүүлсэн биотехникийн арга хэмжээ, хээрийн зэрлэг ан амьтны тандалт судалгаа, эргүүл, хяналт шалгалтын ажлаар явсан шатахууны зардал 3,273,200 (гурван сая хоёр зуун далан гурван мянга хоёр зуун) төгрөг, Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулах сумын төвийн нийтийн их цэвэрлэгээ болон Баянхонгор аймгаас Худаг-Урт 4 дүгээр багийн төв хүртэл улсын чанартай авто зам дагуух цэвэрлэгээнд нийт 1,212,200 (нэг сая хоёр зуун арван хоёр мянга хоёр зуун) төгрөг, Дэлхийн ойн өдрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан “Миний нүдээр-Миний сумын төвийн ногоон байгууламж” сэдэвт гар зургийн уралдаанд зориулж 240,000 (хоёр зуун дөчин мянган) төгрөг, Дэлхийн усны өдрийн хүрээнд ард иргэдийн дунд зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээний шагналд 480,000 (дөрвөн зуун мянган) төгрөг, сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, айл өрхийн хашаанд хийх жишиг хогийн савны загварын уралдааны шагналд 600,000 (зургаан зуун мянган) төгрөг, нийт 5,805,400 (таван сая найман зуун таван мянга дөрвөн зуун) төрөгийг зарцуулсугай.

2. Уг хөрөнгийг байгаль хамгаалах хөтөлбөр зориулалтын зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (С.Хонгорзул), нягтлан бодогч (Ч.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

642201041